



Цаг үе, үйл явдал

“МОД ҮРЖҮҮЛЭГ-АГРОЭКОЛОГИЙН СУРГАЛТЫН ТӨВ”- ИЙГ БАЙГУУЛСНААР ЖИЛД НЭГ САЯ ТАРЬЦ, СУУЛГАЦЫГ БЭЛТГЭНЭ



Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч У.Хүрэлсүх НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 76 дугаар чуулганд оролцох үеэрээ “Монгол Улс 2030 он гэхэд нэг тэрбум мод тарих болно” гэдгийг мэдэгдсэн бөгөөд энэхүү хөдөлгөөнийг монголын нийт ард түмэн, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж бүр идэвхтэй дэмжин, олон арван бүтээлч үйл ажиллагааг өрнүүлсээр байна.

Уг үндэсний хөдөлгөөнийг Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний нийт бие бүрэлдэхүүн идэвхтэй дэмжихийн зэрэгцээ манлайлах үүрэгтэй оролцон, мод тарих, ургуулах, арчлан хамгаалах ажлыг амжилттай гүйцэтгэж байна. Үүний нэг ажил нь өнөөдөр нээлтээ хийж байгаа “Мод үржүүлэг-агроэкологийн сургалтын төв”-ийн нээлтийн үйл ажиллагаа юм.

Тус төвийн нээлтийн үйл ажиллагаанд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга бригадын генерал Д.Ганхуяг, Дорноговь аймгийн Засаг дарга О.Батжаргал, ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга бригадын генерал С.Ганбямба, ЗХЖШ-ын орлогч дарга бригадын генерал Ч.Цогтжаргал, БХЯ-ны СБТГ-ын дарга хурандаа Ч.Гандирваа, БХЗГ-ын дарга хурандаа Б.Түвшинтөр, ГХАГ-ын дарга хурандаа Б.Бат-Эрдэнэ, Зэвсэгт хүчний Барилга-инженерийн цэргийн удирдах газрын дарга хурандаа Х.Батсайхан, Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн штабын дарга хурандаа Д.Дугаррагчаа, Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн захирагч хурандаа А.Болдбаатар нарын хүндэт зочид төлөөлөгчид оролцлоо.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаян тосгонд байгуулж байгаа тус Мод үржүүлэг-агроэкологийн сургалтын төв нь Батлан хамгаалах салбарын олон төслүүдийн нэг хэсэг юм. Энэхүү төвийг байгуулснаар жилд нэг сая тарьц, суулгацыг бэлтгэхийн зэрэгцээ сургалт, судалгааны ажлыг явуулах боломжтой юм. Мод үржүүлэг-агроэкологийн сургалтын төв, мод үржүүлгийн газруудыг 2022-2024 он хүртэл үе шаттайгаар байгуулснаар 2024 оноос эхлэн жилд 9,504,000 ширхэг тарьц, суулгац бэлтгэж нийлүүлэхээр ажиллаж байгаа юм.

Энд онцлоход, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Батлан хамгаалах салбар нь 2021-2030 он хүртэл дараах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр зорилт тавьсан бөгөөд нийт 27 сая мод тарьж, ургуулан ногоон орчныг бий болгох юм.

Модыг нэг газраас огтолж нөгөө газарт тарих бус өөрсдөө ургуулж тарих нь чухал. Энэ талаар Батлан хамгаалахын сайд

Г.Сайханбаяр хэлэхдээ “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг амжилттай хэрэгжүүлэх, цөлжилтийг бууруулах үйл ажиллагаанд батлан хамгаалах салбар манлайлан оролцох учиртай. Тиймээс бид энэхүү хөдөлгөөнийн хүрээнд дараах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Үүнд, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам дагуу ногоон зурвас байгуулах “Ногоон зам”, Мод үржүүлгийн газар, агроэкологийн сургалтын төв, Ногоон хотхон, Хот хоорондын авто замын дагуу ногоон зурвас, Говийн бүсийг ойжуулах “Заг” төслийн зэрэгцээ салбарын алба хаагчдын амьдарч буй орчинд мод тарих, ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх олон төслүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Мөн батлан хамгаалах салбарын алба хаагчдад агроэкологийн мэдлэг олгох, сургагч багш бэлтгэх төсөл, мод үржүүлгийн газар байгуулах зэрэг арга хэмжээг Хөдөө аж ахуйн их сургуулийн Агроэкологийн сургууль, Монголын тариаланчид, гурил үйлдвэрлэгчдийн холбоо, “Эрдэнэс-Тавантолгой” ХХК зэрэг байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэхээр хамтын ажиллагааны гэрээ байгуулсан. Батлан хамгаалах салбар энэхүү төслүүдийн хүрээнд 27 сая мод тарьж ургуулан ногоон эко орчныг бий болгож, байгаль эх дэлхийгээ сэргээх үйлсэд хувь нэмрээ оруулна” гэдгийг онцлолоо.

Цаашид дээрх “Мод үржүүлэг-агроэкологийн сургалтын төв”-ийг улам боловсронгуй болгохын тулд хүлэмж угсрах, худаг гаргах, усжуулалтын системийг байгуулах, хашаа хороо барих, цахилгааны дэд бүтэц зэрэг бүтээн байгуулалтын ажлуудыг 2024 он хүртэл хэрэгжүүлнэ. Ийнхүү “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Улаанбаатар хот болон хангайн бус, говийн бүсэд байрлах Зэвсэгт хүчний 9 ангийн байршилд 7 мод үржүүлгийн газар, 2 Мод үржүүлэг-агроэкологийн сургалтын төвийг байгуулахаар ажиллаж байна. Тодруулбал, Дорноговь аймгийн Өргөн сум Зүүнбаянд Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн 10 га талбай, Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн Өлзийт хороололд Зэвсэгт хүчний 310 дугаар ангийн 8 га талбайд.

Харин мод үржүүлгийн газрыг 1. Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн Сонгинод Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн 2 га талбай; 2. Төв аймгийн Батсүмбэр суманд Зэвсэгт хүчний 017 дугаар ангийн 5 га талбай; 3. Төв аймгийн Алтанбулаг суманд Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн 2 га талбай;

Үргэлжлэл нь арын нүүрт:



Цахим шууданд

“МОД ҮРЖҮҮЛЭГ-АГРОЭКОЛОГИЙН СУРГАЛТЫН ТӨВ”-ИЙГ БАЙГУУЛСНААР ЖИЛД НЭГ САЯ ТАРЬЦ, СУУЛГАЦЫГ БЭЛТГЭНЭ

Түрүүч нь эхний нүүрт:

4. Завхан аймгийн Улиастай хотод Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн 2 га талбайд;
5. Эрдэнэт хотод Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн 3 га талбайд;
6. Говьсүмбэр аймгийн нутагт Зэвсэгт хүчний 011 дүгээр ангийн 4 га талбайд
7. Дорнод аймгийн Чойбалсан суманд Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн эзэмшлийн 3 га талбайд тус тус 39 га талбайд байгуулахаар ажиллаж байгаа юм.

Мөн нэгтгэл, анги, байгууллагын өнгө үзэмжийг дээшлүүлэх, эрүүл ногоон орчныг байгуулах зорилгоор Батлан хамгаалах яамны харьяа байгууллага, Зэвсэгт хүчний нэгтгэл анги, салбаруудын нийт

50 байрлалд 2030 он хүртэл хугацаанд төслийг хэрэгжүүлнэ. Энэхүү төслийн хүрээнд Батлан хамгаалах яамны харьяа байгууллага, Зэвсэгт хүчний нэгтгэл ангиудын байрлалд 800.000 мод бут, сөөг тарьж ургуулах юм. 2022 онд Зэвсэгт хүчний 014, 256, 336, 350, 353 дугаар ангиудыг жишиг эко ногоон хотхон болгохоор зорилт тавин мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах юм. 2021 онд Зэвсэгт хүчний 015 дугаар ангийг жишиг ногоон хотхон болгох зорилтын хүрээнд 14 нэр төрлийн 8485 ширхэг мод, бут, олон наст ургамал бүхий ногоон байгууламж, гэрэлтүүлэг бүхий явган хүний зам, талбай, гүйлтийн зам, спорт тоглоомын талбайг байгуулсан.



БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 336 ДУГААР АНГИД..



Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр энэ өдөр мөн Зэвсэгт хүчний 336 дугаар ангид ажиллалаа. Батлан хамгаалах сайдыг дагалдаж БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга бригадын генерал Д.Ганхуяг, Дорноговь аймгийн Засаг дарга О.Батжаргал, ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга бригадын генерал С.Ганбямба, ЗХЖШ-ын орлогч дарга бригадын генерал Ч.Цогтжаргал, БХЯ-ны СБТГ-ын дарга хурандаа Ч.Гандирваа, БХЗГ-ын дарга хурандаа Б.Түвшинтөр, ГХАГ-ын дарга хурандаа Б.Бат-Эрдэнэ, Зэвсэгт хүчний Барилга-инженерийн цэргийн удирдах газрын дарга хурандаа Х.Батсайхан, Зэвсэгт хүчний Хуурай замын

цэргийн штабын дарга хурандаа Д.Дугаррагчаа, “Монгол генерал” төвийн тэргүүн хошууч генерал С.Баасанхүү нар байлцлаа. Батлан хамгаалахын сайд тэргүүтэй төлөөлөгчид тус ангид хүрэлцэн ирэхэд Зүүнбаян цэргийн хүрээний хүндэт харуул угтан авлаа. Аймгаар орон нутагт явагдаж буй бүтээн байгуулалтын ажлын хүрээнд тус ангид ч нэлээдгүй ажлууд хийгдэж байгаагийн нэг “Эко хотхон” байгуулах төслийг эхлүүлж буй явдал бөгөөд ирсэн зочид энэхүү хотхоны мод тарихад гар бие оролцлоо. Анги, байгууллагын орчны ийнхүү эко хотхон болгосноор тэдгээрийн өнгө, үзэмжийг дээшлүүлэхийн зэрэгцээ экологийн тэнцвэрт байдлыг хадгалахад ихээхэн хувь нэмрээ оруулах юм. Мөн энэ үеэр ангийн түүхт

90 жилийн ойг угтаж жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит цэцэрлэгт хүрээлэнгийн нээлтийн хүндэтгэлийн ажиллагаа зохион байгуулагдлаа. Тус цэцэрлэгт хүрээлэн ангийн чанх урд байгуулагдаж байгаа бөгөөд 400 ширхэг хайлаас модны суулгац, 1000 ширхэг буйлс модны үрийг суулгаснаас гадна усан оргилуур, Жанжин Д.Сүхбаатарын хөшөөг байршуулжээ. Мөн хүндэт самбарт нь их говийн гарнизонд үйл ажиллагааг явуулж байсан ангиудын нэрийг хүндэтгэн залж, мөнхөлсөн нь ихээхэн онцлог болжээ. Үргэлжлүүлээд ангийн захирагч хурандаа А.Болдбаатар ангийн байр, хийгдэж буй бүтээн байгуулалтын ажлуудаа танилцууллаа.



Дарга, ерөнхий редактор, хурандаа САНЖМЯТАВЫН ТӨМӨРХҮЯГ

ЦАХИМ ХАЯГ
Батлан хамгаалах яам
Зэвсэгт хүчний Жанжин штаб

ЦАХИМ ХУУДАС
“Соёмбо” сонин
“Дуулга” студи

* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.
* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.
* Тус сонины мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс: 10018
Цахим шууданд: Soyombo@mod.gov.mn
Утас: 70001029, 3412 (дотуур)